ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 10 сарын 12 өдөр Дугаар А-26/498 Улаанбаатар хот

Суурь бүртгэлийн шинэ систем болон бусад системийг нэвтрүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн дүрэм”-ийн 11 дүгээр зүйлийн 11.6.2, 11.6.13 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Энэхүү тушаалын Хавсралтад заасан хуваарийн дагуу Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн суурь бүртгэлийн шинэ систем болон бусад системийг нэвтрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсугай.

2. Суурь бүртгэлийн шинэ систем болон бусад системийг нэвтрүүлэх хугацаа болон хуваарийн талаарх мэдээллийг 2026 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн харилцагчдад хүргэж ажиллахыг Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч (О.Банзрагч)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хуулбарыг холбогдох газар, хэлтэс, нэгж болон Дотоод аудитын газар (Ч.Лхагвасүрэн)-т хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх удирдлагын ажлын алба (Ц.Отгонтуул)-нд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ 

О.ОРХОН

Худалдаа, хөгжлийн банкны Гүйцэтгэх захирлын
2026 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн
А/221 тоот тушаалын Хавсралт 1

ДЭЛГЭРЭНГҮЙ ХУВААРЬ

Банкны үйлчилгээ	Ажиллахгүй хугацаа	Ажиллаж эхлэх хугацаа
ЦАХИМ БАНК *(TDB Online, Happy Pay, etbdm.mn, SMS)*	10.17-ны 00:00 цагаас ажиллахгүй *(Банк доторх, банк хоорондын орлого, зарлагын бүх гүйлгээ, гадаад шилжүүлэг болон бүх төрлийн төлбөр тооцоо)*	10.19-ний 00:00 цагаас ажиллана
QPAY ГҮЙЛГЭЭ		
САЛБАР, ТООЦООНЫ ТӨВ		10.19-ний 09:00 цагаас ажиллана
APPLE PAY, GOOGLE PAY, БҮХ ТӨЛБӨРИЙН КАРТ	10.17-ны 00:00-03:00 цагийн хооронд ажиллахгүй	10.17-ны 03:01 цагаас ажиллана
	10.18-ны 23:00-00:00 цагийн хооронд ажиллахгүй	10.19-ний 00:01 цагаас ажиллана
ПОС, АТМ *(Картын үйлдэгдэл шалгах, орлого, зарлага)*	Ажиллана	